

АЛТАЙН НУРУУНААС ШИНЭЭР ИЛРҮҮЛСЭН ХАДНЫ ЗУРГИЙН ДУРСГАЛ

Ц. Мөнхбат^{1, *}, Ч. Энхтөр²

Товч агуулга: Энэхүү өгүүллээр Ховд аймгийн Дарви, Зэрэг, Манхан, Чандмань сумдын нутгийг дамнан оршдог Бумбат хайрхан уулын Товорын ам хэмээх дурсгалт газраас шинээр илрүүлэн бүртгэсэн өвөрмөц дүрслэлтэй зарим зургуудыг танилцуулж байна. Хадны зургийг уулын хормой хэсгээс эхлэн орой хүртэл дугаарлаж, нийт 85 хэсэг хаданд 600 гаруй тооны зураг бүртгэсэн ба бид үүнээс дүрслэл зохиомжоор онцлог 42 хэсэг хаданд буй нийт 195 хадны зургийн дүрслэлийн талаар энэ судалгаанд авч үзлээ. Бумбат хайрхны хадны зургуудын он цаг нь хүрэл зэвсгийн үеэс дундад зууны Монголын үе хүртэлх хугацаанд холбогдох боломжтой бөгөөд Монгол Алтайн хадны зурагт дүрслэлээрээ онцгой байр суурь эзэлнэ.

Түлхүүр үг: Хүрлийн үе, хадны зураг, Бумбат хайрхан, Зэрэг, Манхан, Чандмань, Ховд аймаг

Удиртгал

2020 оны зун Манхан сумын Зэрэг гол багийн малчин Б.Төгөлдөр Баян булгийн Цагаан хад хэмээх газарт том хиргисүүрийн өмнө талд хоёр буган хөшөө байгааг мэдээлсэн юм. 2020 оны 8-р сарын сүүлээр бид Олон булаг, Баян булагт зусаж байгаа нутгийн хүмүүсээр газарчлуулан тэр хавиар багахан хэмжээний хайгуул хийж, Баатарын нурууны (нутгийнхан Баатарын нурууг хүндэтгэн оройд нь мөнхөд байх цасаар Цаст хэмээн нэрлэдэг) арын хормой орчмоос урьд өмнө бүртгэгдээгүй гурван буган хөшөөг шинээр бүртгэн баримтжуулав.

Цагаан хадны хиргисүүрийн өмнөх буган хөшөөд нь өндөр довцог толгод дээр төв замын хажууд ил харагдах ба бид гэрэл зургаар баримтжуулан тодорхойлолт зэргийг үйлдэв. Цагаан хадны буган хөшөөдийг өмнө нь 2017 онд Ховд их сургуулийн багш Ч.Мөнхбаяр газар зүйн судлаачдын хамт морин аяллаар Баатарын нуруунд явж байхдаа анх олж харсан байдаг. Хөшөөнүүдийн талаар ямар нэгэн өгүүлэл, илтгэл бичилгүй аяллын тайландаа оруулсан хэмээн өгүүлэв. Буган хөшөөдийг баримтжуулсны дараа Б.Төгөлдөрийнд ирж энэхүү хөшөөг хэзээ анх харсан ойр хавьд өөр түүх соёлын дурсгал бий эсэхийг асуухад өөрийн өвөлждөг Бумбат хайрхан ууланд маш олон тооны хадны зургийн дурсгал байдаг хэмээн өгүүлсэн.

Улмаар бид 9-р сарын дундуур Б.Төгөлдөрөөр замчлуулан Бумбат хайрхан уулын Шар булаг, Товорын амны хадны зургуудыг бүртгэн баримтжуулав.

Бумбат хайрхан уул нь Ховд аймгийн Чандмань, Зэрэг, Манхан, Дарви сумуудын нутгийг дамнан оршдог сүрлэг хайрхан юм. Уг уул нь далайн түвшнээс дээш 3464 м өндөрт оршдог. Бумбат хайрхан ууланд Зэрэг сум талаасаа Салхит, Баян хайрхан, Буйласт, Улаан хонд, Бялзуухай, Улиастай, Торлог, Хоогийн худаг, Өлийн ам, Шар булаг, Товор зэрэг түүх соёлын дурсгалуудаар элбэг олон ам бий.

Бумбат хайрхан уулын ойр орчим байх түүх соёлын дурсгалуудыг судлан шинжлэх ажил XX зууны дунд үеэс эхэлсэн.

Анх 1959 онд нэрт эрдэмтэн түүхч Х.Пэрлээ Бумбат хайрхан уулын баруун өмнөд бэл Дарви сумын нутагт хамаарах хэсэг Байшин үзүүрийн Жүргэрийн цагаан толгой хэмээх газраас эртний Түрэг бичээс илрүүлжээ. 1969-1970 онд Монгол-Зөвлөлтийн хамтарсан шинжилгээний ангийн “Гэрэлт хөшөө хад чулууны бичээс судлах анги” газар дээр нь нягтлан үзэж, түрэгч М.Шинэхүү тайлан уншсан байна (Шинэхүү 1972: 135-142).

Зөвлөлтийн эрдэмтэн В.В.Волков Бумбат хайрхан уулын өмнөд бэл Дарви сумын нутаг Чулуутын огтрог хэмээх газраас морин тэрэг хөллөсөн дүрслэлтэй гурван буган хөшөөг шинээр илрүүлэн эрдэм шинжилгээний эргэлтэд оруулжээ (Волков 1980). Энэхүү судалгаа нь тухайн цаг үедээ буган хөшөөн дээр морин тэрэг сийлсэн анхны тохиолдол байлаа.

Мөн Ховд их сургуулийн багш доктор Ч.Мөнхбаяр Бумбат хайрхан уулнаас хадны зургийн дурсгал шинээр илрүүлэн эрдэм шинжилгээний эргэлтэн оруулжээ (Мөнхбаяр 2014: 42).

Бид 2016 онд Бумбат хайрхан уулын Өлийн ам, Хөх өндрийн бэл хэмээх газруудаас 36 газарт 500 гаруй зохиомж бүхий хүрэл зэвсгийн үеэс төмрийн түрүү үе хүртэлх хугацаанд зурагдсан үлдсэн хадны зургийн

¹ Ховд, Манхан, Ерөнхий боловсролын сургууль,

* Холбоо барих зохиогч: tismunkhbat27@gmail.com

² Ховд, Манхан, Ерөнхий боловсролын сургууль

дурсгалыг шинээр илрүүлж эрдэм шинжилгээний эргэлтэд оруулсан (Энхтөр, Мөнхбат 2016: 13-20).

Хадны зургийн тархалт, ангилал, дүр дүрслэлийн арга барил

Товорын амны хадны зургууд нь уулын хормой бэлээс эхлэн уулын дунд хэсэг хүртэлх хад болгонд зурагдан үлджээ. Цөөн тооны зургууд нь байгаль цаг уурын онцлог, он цагийн уртад бүдгэрэн арилах зүйл ажиглагдсан бол ихэнх зургууд нь тод, анх зурагдсан мэт хэвээрээ байна. Хөндий тал газар биш уулын бэл наран эвээр газарт салхи харьцангуй бага учир хадны зургууд нь хадгалалт сайтай. Зарим хаданд ганц янгирыг дүрсэлсэн байхад өөр нэгэн хаданд хүмүүсийн үйл ажиллагаа, ан агнуур зэрэг үйл явдлыг дүрсэлсэн тохиолдол ажиглагдана. Бид зургуудыг бүртгэхдээ уулын бэлээс эхлэн дугаарлаж, дунд хэсэг хүрэхэд том жижиг 85 хэсэг хаданд 600 гаруй тооны зураг байх ба дүрслэл зохиомжоор өвөрмөц 42 хаданд байх 195 гаруй тооны зургийн сонгон энд өгүүлэхээр зорив. Ан амьтны хувьд 6 төрлийн амьтад, мөн үл танигдах амьтны дүрслэл бий. Эдгээрийг тус тусад нь авч үзвэл: янгир 400, буга 13, араатан 54, адуу 5, тэмээ 4, гөрөөс 14, нохой 8, могой 1, аргаль 2 тус тус дүрслэгджээ.

Бид хавсралт зургийг үйлдэхдээ амьтны төрөл зүйлээр нь ялгалгүй хаданд зурагдсан зургуудыг тэр хэвээр нь судлаачдад харуулахыг зорилоо. Учир нь төрөл зүйлээр нь ялгасан тохиолдолд хадны зургийн зохиомж, үйл явдал, дүрслэлийн онцлог зэргийг харах боломжгүй болдог билээ. Товорын хадны зургууд сийлмэл зургийн төрөлд багтах бөгөөд тэдгээрийг дүрсэлсэн байдлаас харахад энгийн хялбарчилсан буюу тоймлох арга зонхилох боловч бодит байдлаар дүрсэлсэн зураг цөөнгүй бий.

Ингэж дүрслэхдээ ерөнхийд нь: бүх талбайгаар нь хонхойлон цохих гадаад тэгийг хөвөөлөн цохих гэсэн хоёр аргыг ашиглажээ.

Хадны зургийг төрөл зүйлээр нь сэдэвчлэн ангилах нь зургийн утга зүй, үйл явдал тэдгээр зургийг зурсан хүмүүсийн эрхэлж байсан аж ахуй, соёл, шашин шүтлэг, ертөнцийг үзэх үзэл, оюун санааны хөгжил зэргийг сэргээн тодруулахад чухал ач холбогдолтой байдаг тул Товорын хадны зургуудыг сэдэв зохиомжийн хувьд дараах байдлаар ангилан үзэх саналтай байна.

Үүнд: Өгүүлэн буй хадны зурагт ан амьтдын сэдэвт зохиомжит зургууд зонхилох байр суурь эзлэх бол үүний дараагаар аж байдлын сэдэвт зургууд нэлээд бий. Мөн Монгол орны нутгаас маш цөөн тоотой илрээд буй могойны дүрслэл ч бас тааралдана.

Уг дурсгалт газрын зургуудыг сэдэв дүрслэлийн хувьд, ан амьтдын сэдэвт (зэрлэг ба гэршүүлсэн

амьтад); аж байдлын сэдэвт (хүн, морь, тэмээ унаж эдэлж буй); ан агнуур (нум сумтай анчин аргал, янгирыг харваж буй); тодорхой бус дүрслэл гэж ангилав.

Хадны зургийн тодорхойлолт

Зураг-1. Нэгэн зүгт харсан гурван янгирыг болхидуу дүрсэлсэн. Янгируудыг дээр дээрээс нь давхарлуулан зуржээ.

Зураг-2. Ишгээ дагуулан явж буй янгирын дүрслэл. Ишгийг эхийнхээ араас харайж буйгаар харин эхийг нь толгойгоо гудайлган тайван зогсож байгаагаар урласан.

Зураг-3. Бүх биеэр нь доошоо харсан чиглэлтэй ганц янгирыг дүрсэлжээ.

Зураг-4. Мушгирсан эвэртэй алсыг харан тайван зогсож, буй нэг янгирыг бүх талбайгаар нь хонхойлон цохижээ.

Зураг-5. Өөд өөдөөсөө харсан хоёр янгирын дүрслэл. Урт сахалтай том тэхийн урдаас жижигхэн янгир зогсож буйгаар урласан.

Зураг-6. Цувран яваа хоёр янгирыг дүрсэлсэн. Эхэнд нь яваа янгирын эврийг нумарсан уртаар урласан.

Зураг-7. Нэгэн зүгт харайж байгаа есөн тооны янгир, янгирын ишгийг нум сумтай анчны урдаас давхиж буйгаар урласан. Зугтаж буй янгирын сүрэг дунд жижиг биетэй араатан амьтан агнах амьтныхаа араас хөөж байхад хөлөө алцан зогссон нум сумтай анчин сүргийн эгц урдаас нумаа эвшээлгэн татаж буйгаар зургийг дүрсэлжээ.

Зураг-8. Бүх биеийг нь болхи дүрсэлсэн нэгэн янгирыг зурсан.

Зураг-9. Бүх бие хөлийг нь нарийн гоёмсог дүрсэлсэн тайван зогсож буй нэгэн янгирыг дүрсэлсэн.

Зураг-10. Гурван янгирыг дүрсэлсэн. Эдгээрийн захын хоёр янгирыг баруун зүг рүү хандан нэгэн зүгт тайван зогсож, буйгаар урласан бол дунд нь байх нэг янгирын толгой, цээжин хэсгийг дүрслээд эсрэг зүүн тийш толгойг хандуулан дүрсэлжээ.

Зураг-11. Зээр гэж хэлж болмоор амьтны ард олон салаа эвэртэй урд хөлөө нугалан зогсож, буй гоёмсог дүрслэлтэй бугыг урлажээ.

Зураг-12. Болхи дүрслэлтэй гурван янгирын хажууд нэгэн хүнийг дүрсэлсэн.

Зураг-13. Нумарсан эвэртэй амаа ангайн хэвтэж буй гоёмсог дүрслэлтэй нэг янгирыг урласан.

Зураг-14. Тайван зогсож буй олон салаа эвэртэй бугын эвэр дээр харайж буй гоёмсог зурсан янгирыг дүрсэлжээ.

Зураг-15. Нэгэн зүгт харсан гурван янгирыг дээр дээрээс нь давхарлан зуржээ.

Зураг-16. Болхи дүрслэлтэй хүнийг урласан.

Эрэгтэй хүн гэдгийг харуулахын тулд бэлэг эрхтэн дүрсэлжээ.

Зураг-17. Хөлөө нугалан хэвтэж буй янгирыг урласан.

Зураг-18. Хоёр янгирыг дүрсэлсэн ба урд талд нь үл танигдах нэгэн зүйлийг урлажээ.

Зураг-19. Болхи дүрсэлсэн хоёр янгирыг нэгэн зүгт харснаар дүрсэлжээ.

Зураг-20. Гоёмсог дүрсэлсэн нэг янгирыг урласан. Янгирыг дүрслэхдээ гадаад талбайг хөвөөлөн цохих аргаар сийлсэн.

Зураг-21. Толгой, хүзүүг уран гоёмсог дүрсэлсэн тэмээний дээд талд харайж буй янгирын ишгийг дүрсэлсэн.

Зураг-22. Хоёр морьтон, таван янгир, нэг тэмээг сийлжээ. Хоёр морьтныг баруун зүг явж буйгаар хандуулан дүрсэлсэн бол нэг нь морин дээрээсээ хойш эргэн ардаа байх янгирыг харвахаар нумаа эвшээлгэж буйгаар урлажээ. Хоёр янгирын нэгийг бүх талбайгаар нь хонхойлон цохисон бол нөгөө янгирыг их бие, урд хөлийн дээд булчин хэсгийг цохилгүй үлдээсэн нь магадгүй нас гүйцсэн харлаг тэхийн биеийн өнгийг дүрсэлсэн гэж хэлж болохоор байна. Хамгийн дээд талд нь толгойгоо гэдийлгэн зогсож буй тэмээ түүний дор болхи дүрсэлсэн гурван янгирыг давхарлуулан дүрсэлсэн.

Зураг-23. Харайж буй янгирыг бүх талбайгаар нь хонхойлон цохижээ.

Зураг-24. Болхи дүрслэлтэй морьтны дээд талд гадаад талбайг нь хөвөөлөн цохисон үл танигдах амьтныг дүрсэлсэн. Сайтар ажиглавал тэмээ гэж хэлж болмоор санагдана.

Зураг-25. Хоорондоо бага зэргийн зайтай ар араасаа цувран яваа хоёр янгирыг сийлсэн. Янгирuудыг дүрслэхдээ гадаад талбайгаар нь хөвөөлөн цохих аргыг ашиглажээ. Эхний янгирын толгой, эвэр, их биеийг уран гоёмсог урласан ба хөлийн тавилтыг алхалтын хэмнэлээр мэдрэмжтэй урлажээ.

Зураг-26. Олон салаа эвэртэй том бугын дээд талд гурван араатан нэг янгирыг дүрсэлжээ. Араатан амьтныг сайтар ажиглавал буга руу дайрч байгаа бололтой. Бугын эвэр, нүд, амыг гоёмсгоор сийлжээ. Алс зайд буга руу дайрч байгаа хоёр араатныг тайван харан зогсож буй нэг янгирыг дүрсэлсэн ба түүний урдаас өөр нэг араатан дөхөж буйг тов тодорхой харуулжээ.

Зураг-27. Гадаад талбайгаар нь хөвөөлөн цохисон үхэр түүний доод талд гурван янгирыг урлажээ. Хоёр янгирын хошууг өргөн зураасаар нийлүүлсэн ба толгой цээжин хэсгийг урлаад нуруу, зоо хэсгийг дүрслэлгүй орхижээ.

Зураг-28. Найман салаа эвэртэй ганц бугыг дүрсэлсэн. Бугын нүдийг гоёмсгоор гаргажээ.

Зураг-29. Угалзарсан эвэртэй нас бие гүйцсэн

аргалыг гадаад талбайгаар нь хөвөөлөн цохих аргыг ашиглаж сийлжээ. Харайж байгаа аргалын хондлой, сүүл рүү 8 см урт мөстэй сум зоогдсоноор урласан. Аргалын дээд талд гурван жижиг янгирыг дүрсэлсэн.

Зураг-30. Энэхүү зурагт олон тооны амьтан, өгүүлэмжийг дүрсэлсэн. Олон янгир, буга, араатан амьтдын дунд морь, тэмээ унасан хүмүүсийг дүрслэхийн сацуу сундлаатай морь унасан хүнийг ч дүрсэлсэн тохиолдол бий.

Зураг-31. Нэгэн хаданд олон төрлийн амьтныг дүрсэлсэн. Олон янгирuудын дунд ан хийхээр сунан харайж буй чоныг тодорхой харуулсан.

Зураг-32. Уран гоёмсог сийлсэн морьтныг дүрсэлсэн. Морины чихийг урагшаа соотон дүрсэлсэн энэ нь морь алсыг харан тэмүүлж буйг илтгэсэн. Хараа сунган тэмүүлж буй морины амыг морь унаж буй хүн гэдийн татаж буйг тов тодорхой харуулжээ. Морьтны хөлийг унжсанаар дүрсэлсэн ба хөлийн цаад талд гөлөм гэж хэлж болохоор зүйлийг урлажээ. Морины сүүлийг газар унжин чирэгдсэн байдалтай уртаар дүрсэлсэн.

Зураг-33. Үсээ хойшоо задгай тавьж, хөлөө унжуулсан хүнийг гоёмсог дүрслэлтэй тэмээ унаж буйгаар сийлсэн. Тэмээний толгой, хүзүүг, хөлийг уран гаргасан ба сүүлийг хойш модойлгосон байдлаар урласан.

Зураг-34. Ар араасаа цувран нэгэн зүгт харайж буй олон янгирыг дүрсэлсэн. Янгирын сүргийн хойноос нэг араатан хөөж байгаа бол сүргийн дээд талаас өөр нэг араатан харайн ирж буйг тод томруунаар урласан.

Зураг-35. Хоёр янгирыг дүрсэлсэн. Нэг янгирын араас араатан амьтан хөөж буйгаар дүрсэлсэн бол, нөгөө янгир нь ишгээ хөхүүлэн тайван зогсож буйгаар урлажээ.

Зураг-36. Урд урдаасаа харан зогсож буй янгирuудын дээд талд тэдний зүг харайж буй араатныг дүрсэлсэн. Араатны хойд хөлийг үхэр мэт том амьтантай холбожээ.

Зураг-37. Янгир гэж болохоор амьтныг болхидуу дүрсэлсэн.

Зураг-38. Нэгэн хаднаа 30 гаруй см урттай мушгиралдан дээшээ чиглэлтэй зураасыг баруун зүг хандуулан дүрсэлсэн. Дээд талын үзүүрт байх дугуй зүйл нь ямар нэгэн амьтны толгой мэт харагдана. Энэхүү дүрсийг могойн дүрслэл болов уу хэмээн таамаглаж байна.

Зураг-39. Гоёмсог дүрслэлтэй морьтныг сийлсэн. Морь унаж, нум сум харван буй хүнийг малгай өмссөн, хоёр хөлөө унжуулсан байдалтайгаар дүрсэлсэн. Морины урд хөл алхаж байхад хойд хөлийг хөдөлгөөнгүй зогсон буйгаар урлажээ. Алсыг ширтэн хихээ соотойлгон байгаа морины гэдсийг бүхэлд нь бүрхсэн гөлөм гэж хэлмээр зүйлийг дүрсэлжээ.

Зураг-40. Таван янгирын дунд хоёр нум сум агссан

морьтон янгир хөөж буй зургийг сийлсэн. Дээрх өгүүлэмжтэй зургийн доод талд давхиж буй хоёр янгирог урлажээ. Мөн олон янгирын дунд ан хийж байгаа нум сумтай морьтны дүрслэл сонирхолтой юм. Жолоо эсвэл цулбуурыг морины хүзүү доогуур унжсан байдлаар урласан бол маш өргөн гөлөм гэж хэлмээр зүйлийг дүрсэлжээ.

Зураг-41. Толгой, цээжин хэсгийг бүх талбайгаар нь хонхойлгон цохиод, их биеийг дүрслэхдээ гадаад тэгийг хөвөөлөн цохих аргыг ашигласан буга, эсвэл хандгай гэж хэлмээр нэгэн амьтны дүрслэл бий. Уг амьтны нүдийг дугуй жижиг цэгээр дүрсэлсэн.

Зураг-42. Амьтны цувж, явах нарийн зам дээр цувран яваа есөн янгир болон нэг чоныг дүрсэлсэн. Эхний дөрвөн том янгирын дунд нэг жижиг ишиг түүний араас мөн дөрвөн янгирог урласан. Цувж яваа янгиргуудын араас харайж буй чоныг дүрсэлжээ. Эдгээр янгиргууд нь магадгүй усанд ирж байгаа эсвэл усанд ороод гарч буй гэмээр санагдана. Тэдний доод талд хоёр эгнээ 8 янгирог гоёмсог дүрсэлсэн.

Аж байдлын сэдэвт дүрслэл. Бумбат хайрхан уулын Товорын амны хадны зурагт хүн, түүний үйл ажиллагааны бүх талыг харуулсан зургууд багтах ба үүнд хүмүүсийн эрхэлж байсан аж ахуй, соёл зэргийг хамруулан үзэж болно. Эндэхийн хадны зурагт хүний үйл ажиллагааг харуулсан дүрслэл нэлээд бий. Хүнийг морь, тэмээ унаж буйгаар дүрсэлжээ. Тэмээ унаж буй нэгэн хүний дүрслэл байх ба дөрөө дөрөөлөөгүй гэдгийн тодотгохын тулд хөлийн урт унжсан байдалтайгаар сийлжээ (Хавсралт 2, Зураг 3). Тэмээ унаж яваа хүнийг хойшоо унжсан урт үстэй байдлаар хадны зурагт дүрсэлсэн. Монгол орны нутаг дэвсгэр болон хилийн чанадаас олдсон хадны зурагт хүнийг үстэй дүрсэлсэн тохиолдол хэд хэд бий.

Шивээт хайрхан уулын Хар салаа I дурсгалт газраас судлаачид эртний гэр бүлийн зураг дээр эрчүүд нь малгайгүй, харин толгойдоо өдөн титэм өмссөнөөр (толгой дээр нь олон богино зураас гаргасан) дүрслэгдсэн үүнийг зарим судлаачид богино зассан үсийг ч дүрсэлсэн байж болно хэмээн үздэг (зур. 443). Хар салаа I зурган дээр үсээ янзалсан хүний дүрс олдсон байдаг (Хавсралт 2, Зураг 16). Тэрээр үсээ олон хэсэг болгон сүлжээд мөрөн дээгүүрээ унжуулсан, чинжаал хутга, саадаг, бамбайгаар зэвсэглэсэн байна. Нэгэн морин тэрэгтэй хүн үсээ сүлжсэн юм уу, боосон зураг олдсон юм (Цэвээндорж нар 2010: 13; зур. 627). Урт үстэй болохоор шууд эмэгтэй хүнийг дүрсэлсэн гэж ойлгож болохгүй эрэгтэй хүнийг ч урт үстэйгээр дүрсэлсэн тохиолдол тааралддаг хэмээн зарим судлаачид өөрсдийн бүтээлдээ тэмдэглэсэн нь бий.

Оросын судлаач Н.В.Полосьмакийн үзэж буйгаар

эрэгтэй хүн гэзэгтэй байх нь эртний уламжлалт олон соёлд ердийн үзэгдэл байсан. Тэрээр Укокийн Верх-Кальджин-2 оршуулгын газрын 3-р булшнаас гарсан залуу эрийн занданшуулсан шарилын үс нь мөрөө давсан урт, 2 хэсэг сүлжсэн шаргал үстэй байжээ (Цэвээндорж нар 2010: 13).

Гөлөм дүрсэлсэн нь: Товорын хадны зурагт морь унасан хүнийг олон янзаар дүрсэлсэн. Сүрэг янгирын дунд морины чихийг урагшаа соотон алсыг харан хараа сунган тэмүүлж буй морины амыг унаж буй хүн гэдгийн татаж буйг тодорхой харуулсан. Морины хүзүү, цээж, хэнхдэг хэсгийг өргөн, морины гэдсийг шавхруун нарийхнаар урласан. Морины гуяыг өргөн дүрсэлсэн бол урт сүүлний үзүүр хэсгийг өргөн газар унжсан байдлаар дүрсэлжээ. Мориныхоо амыг татаад гэдгийн (Зураг-30,32) явж буй нэгэн морьтныг дүрсэлсэн. Өөр нэгэн хаданд хоёр янгирын араас нум сумтай нэг морьтон түүний араас гурван янгирог харваж буй нум сумтай морьтныг сийлсэн (зураг-40). Эхний морины хойд хөлийг зогсож байгаагаар урд хөлийг урагшаа алхсан байдалтай жолоо, цулбуурыг доош унжсан байдлаар дүрсэлсэн. Морины гэдэснээс илүү гарч унжсан дөрвөлжин гөлмийг дүрсэлсэн (Зураг 39). Морины гэдэс гөлөм хоёрын дунд хүний хоёр хөлийг унжсанаар дүрсэлсэн. Нум сумыг болхи дүрсэлсэн ба нумыг зүүн гараар барьж баруун гараар татаж байгаа нь илт мэдэгдэнэ. Товорын хадны зурагт дүрслэгдсэн (Зураг 30, 32, 40) морьтой хүмүүсийн дүрслэл дотор сонирхол татсан зургийн он цагийг тогтооход баримт болох чухал нэгэн дүрслэл бол гөлмийн дүрслэл юм. Эхний гөлөм нь (Зураг 30,32) трапец хэлбэртэй ба гөлмөөс нэгэн зүйлийг зүүсэн байдалтай дүрсэлсэн. Цохилтын өнгө зэргийг сайтар ажиглавал сүүлд цохисон нь мэдэгдэнэ.

Хоёр дахь гөлмийг битүү биш дөрвөлжин хүрээг гаргаж өгөөд дунд нь хүний хөл харагдаж буй нэлээд том хэмжээтэй дүрсэлж өгсөн (Зураг 39).

Монгол болон хил залгаа нутгаас илэрч олдоод буй хадны зурагт морьтой хүний морины эмээлийн гөлмийг дүрсэлсэн зураг, баримал, ханын зураг нэлээд байна. Гөлмийн тухай ярихын өмнө эмээлийн үүсэл, хөгжил хувьслын тухай ярих нь зүйтэй. Дэлхийн дахины адууны тоног хэрэгслийн түүхэнд НТӨ IX-VII зууны үеийн Ассирын морьтон дайчдыг дүрсэлсэн хагас товгор сийлбэрүүдэд эмээлийн эртний хэлбэр хударгатай тохом маягийн дүрслэл байдаг нь хамгийн эртний баримт хэмээн тооцогддог (Баярсайхан 2014: 109-212).

Нүүдэлчдийн эмээлийн эртний түүхэн баримт нь НТӨ VI зууны үед холбогдох бөгөөд Алтайн уулархаг нутагт малтсан НТӨ VI-III зууны үед холбогдох “Пазырыкийн” булшнаас гоёмсог чимэглэлтэй эмээл, хазаар, хударга, хөмөлдөрөг зэрэг адууны тоног хэрэгсэл олноор гарсан байна (Баярсайхан 2014: 109-

212). Пазырык эмээл нь тохом мэт өргөн дөрвөлжин зөөлөвч бүхий хударга, хөмөлдөртэй голоороо нэг олом даруулгатай. Эмээлийн хажуу талаас элдэв төрлийн цацаг чимэг зүүхээс гадна, эмээлийн зөөлөвчний урд болон хойд талыг сийлбэртэй нимгэн ясан наалтаар чимдэг байв.

Хүннүгийн язгууртнуудын цогцолбор булш бүхий Ноён уулын 6-р булшнаас эмээлийн бүүрэг болон хавтасны модон хэсгүүд гарсныг зарим судлаачид дөрвөлжин бүүрэгтэй, гадагш гэдгэрдүү өргөн, урт хавтастай бөгөөд хавтасны дөрөөний сур, жирэм, олмын сагалдарга оруулах нүх нь орчин үеийн монгол эмээлтэй төстэй хэмээн тодорхойлсон байдаг (Доржсүрэн 1961: 29). 2012 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэмтэд Ховд аймгийн Булган сумын нутаг Авын Хөх уулын Хүннүгийн үеийн нэгэн булшнаас гарсан нумын эвэр наалт дээр хударга, хөмөлдөртэй, өргөн уужим суудалтай эмээл бүхий морь дүрслэсэн олдворыг илрүүлсэн нь Хүннү нар модон эмээлийг уналга эдэлгээнд хэрэглэж байсны баримт юм (Батсүх нар 2012: 202-212).

Алтай-Саяны уулсын сав газар, Тэнгэр уул зэрэг өргөн уудам нутагт түгэн тархсан Түрэгийн үеийн булш оршуулгаас эмээлийн мод, бүүрэг, хавтас зэрэг тоног хэрэгслүүд гарсан. Тэр үеийн эмээлийн урд хойд бүүрэг намхан дугуй хэлбэртэй, өргөн хавтастай, хавтасны хажуу доод тал руу буюу дөрөөн сур татах хэсэг рүү тусгайлан өргөсгөж, хавтасны хоёр хажуу талыг голлуулан нэлээд дээхэн дөрөөн сур орох тэгш өнцөгт хэлбэрийн нүх тус бүр нэгийг зарим тохиолдолд хоёрыг гаргасан байдаг (Баярсайхан 2014: 109-212).

Гимей музейн сан хөмрөгт хадгалагдаж буй шавар баримал морины дүрс бий. Энэхүү баримал нь хоёр чихээ соотойлгон хамраа сартайлгасан бахим хүзүүтэй моринд урд бүүрэг нь өндөр хойд бүүрэг нь намхан далбагар том, өргөн гөлөмтэй эмээлийг дүрсэлсэн. Энэхүү шавар баримлын холбогдох он цагийг түрүү дундад зууны үеийн Монгол табгач аймгийн нүүдэлчдийн морины тоног хэрэгсэл хэмээн судлаачид үздэг (Хавсралт 2, Зураг 13) (Баярсайхан 2014: 109-212).

Өмнөговь аймгийн Булган сумын Гөлөөн уул, Хадна уулын зураг дахь гөлөмтэй морь унасан баатрын дүрслэлийг судлаачид Түрэгийн үед холбогдуулан үзсэн (Идэрхангай нар 2020: 129-141) (Хавсралт 3, Зураг 4-5). Түрэгийн үеийн хадны зурагт ихэвчлэн ажиглагддаг нэг зүйл бол хадны зураг дээрх морийг маш нямбай дүрсэлдэг харин хүнийг ихэд болхи байдлаар тоймлон зурсан байдаг (Цэвээндорж нар 2010: 22). Бидний судлан буй дээрх морьтон баатруудын дүрслэлтэй ойролцоо шинж төрх бүхий дүрслэлүүд зарим газрын хадны зурагт цөөнгүй дүрслэгдсэн байдаг. Үүнд: Баян-

Өлгий аймгийн Цэнгэл сумын нутаг дахь Шивээт Хайрханы Хар салаа, Өмнөговь аймгийн Ноён сумын нутаг дахь Ноён богд уулын Дунд хоргын шар даваа зэрэг дурсгалт газруудыг дурдаж болно (Цэвээндорж нар 2010: 22). Шивээт хайрхны хадны зураг дахь морьтон баатруудыг Д.Цэвээндорж нарын судлаачид дүрслэлийн онцлог, арга барилд тулгуурлан ...“Түрэгийн үеийн морьтнуудын хөлийг ихэнх тохиолдолд харуулдаггүй (эмээлийн дөрөөг морины гэдэснээс доош унжуулдаггүй гэж үзсэн бололтой). Харин хүрлийн төгсгөл болон скифийн үеийн морьтнуудын хөл нь бараг газар шүргэж байгаагаар дүрслэгдсэн байдаг билээ” хэмээн морьтнуудын он цагийг тогтоох сонирхолтой дүгнэлт хийсэн байна.

Шивээт хайрхны Хар салаа III-ийн хадан дээр сийлсэн морьдын хэвлийгээс доош ялимгүй унжсан жижиг зүйлийг эмээлийн дөрөө гэж үзсэн ба эртний Түрэгүүдийн морьтой оршуулгаас илэрдэг эмээлийн дөрөөтэй холбон тэдгээр дүрслэлийг Түрэгийн үед хамааруулсан бол хүний хөлийг морины хэвлийгээс доош урт унжуулсан морьтнуудыг хүрлийн үед хамааруулан үзжээ (Идэрхангай нар 2020: 129-141).

Өмнөговь аймгийн Булган сумын Хавцгайтын хаданд дүрслэгдсэн морьтон баатруудын дүрслэлүүдийг судлаачид Монголын үед холбогдуулан үзсэн. Учир нь тус дурсгалт газрын 52-р хадны зураг дахь Монголын үеийн язгууртан ноёдын дүрслэлтэй нэг дор дүрслэгдсэнээс гадна, цохилтын талбайн өнгө, дүрслэлийн хэв маягаараа энэ үед холбогдоно (Идэрхангай нар 2020: 129-141).

1995 оны 6-р сард МУИС-ийн Түүхийн тэнхимийн эрхлэгч профессор Д.Хүүхэнбаатар оюутны дадлага удирдаж явахдаа Дэл уулын Зүүн Билүүний амны дунд биений Хөтөл Билүүний худаг орчмоос нарийн зураасаар сийлбэрлэсэн морьтой хүмүүсийн зураг олжээ. Дэл уулын морьтнуудын зургийг дээрх судлаачид VII зууны хоёрдугаар хагаст Төв Азид нөлөөгөө тогтоосон “Теле” буюу түүний нэг том салбар аймаг болох Уйгуруудын бүтээсэн дурсгал гэсэн таамаглалыг дэвшүүлжээ (Батсүрэн, Хүүхэнбаатар 2006: 28-29).

Сүүлээ өргөсөн, согсой үс нь боссон, гөлөм дүрсэлсэн морийг малгай өмссөн морьтон унаж буй дүрслэлийг тухайн үеийн Улаанбаатарын их сургуулийн судлаачид Өмнөговь аймгийн Булган сумын Хавцгайт хэмээх газраас шинээр илрүүлсэн. Энэхүү зургийн хажууд нь байх тэрэг, богтаг малгайтай хүний дүрслэл зэргийг үндэслэн Монголын үед холбогдуулан үзсэн (Идэрхангай нар 2017).

2017 онд Дундговь аймгийн Өлзийт сумын нутаг Дэл уулын Баруун билүүний баруун хойд шувтарга орчмоос тоймлон зурсан морь унасан хүний 3 дүрслэл илрүүлсэн. Нэгдүгээр хэсэг дэх эхний морьтныг тойм төдий дүрсэлсэн ч гартаа богино уурга барьсан

маягаар дүрсэлсэн ихэд өвөрмөц харагдана. Хоёр дахь морьтон хүнийг дүрслэхдээ бөөрөнхий жижиг толгой, хэдэн зураас төдийгөөр дүрсэлсэн байна. Дөрөвдүгээр хэсэг дэх морьтой хүнийг шувуу шиг нарийн цээж, толгойтой дүрсэлж, хөл гарыг тодорхой дүрслэлгүй үлдээжээ. Морины толгой биеийг зураасаар тойм дүрслээд хүний хөлийг дүрслээгүй бөгөөд хөл тусаа нь тод зураасаар дөрвөлжин гөлөм гэж хэлж болохоор зүйлийг сийлжээ. Энэхүү зургийн он цагийг судлаачид Монголын үед холбогдуулан үздэг (Сүхбаатар нар 2017: 122-131).

Монгол орны нутаг дэвсгэрээс илрүүлэн олсон гөлөмтэй морьтны дүрслэлийг судлаачид Түрэг болон Монголын үед холбогдуулан үздэг. Монголын үед холбогдох морьтны дүрслэлүүд нь гол төлөв говийн бүс нутгаар тархсан хадны зурагт Монголын үед холбогдох хадны зургуудтай хамт зурагдсанаараа онцлог юм.

Говийн бүс нутгаас гадна Алтай нуруугаар тархсан хадны зурагт морьтнуудын унаж буй морийг уран нарийн дүрсэлсэн хэдий ч хүнийг болхи дүрсэлсэн ийм зургуудыг судлаачид Түрэгийн үед холбогдуулан үзэх санал дэвшүүлсэн байдаг (Цэвээндорж нар 2010). Бидэнд олдсон гөлөмтэй морьтныг дүрсэлсэн хадны зургийн материалыг ажиглахад морины сүүлийг хоёр өөрөөр дүрсэлсэн байх юм. Түрэгийн үед холбогдох боломжтой хадны зургуудад сүүлийг морины хондлой дагуулан доошоо унжуулан дүрсэлсэн зүйл ажиглагдана. Ийм зургууд Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Цагаан толгойн хийдийн турийн баруун урд талд, голын сайрын зүүн эргийн хадны зураг (Хавсралт 3, Зураг 2), Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Цагаан толгойн хадны зурагт (Хавсралт 3, Зураг 3), Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Гөлөөн уулын хадны зураг (Хавсралт 3, Зураг 4, 5) зэрэгт дүрслэгдсэн байна.

Харин говийн бүсийн зарим нутгаас Өмнөговь аймгийн Булган сумын Хавцгайтын хадны зураг (Хавсралт 3, Зураг 6, 7, 8), Өмнөговь аймгийн Булган сумын Хадна уулын хадны зурагт (Хавсралт 3, Зураг 9, 10), дүрслэгдсэн морьтнуудын морины сүүлийг цомцойлгон, дээш цацарч, годойлгон дүрсэлсэн нь бас онцлог бололтой. Ийм байдлаар дүрсэлсэн хадны зургийг судлаачид хажууд байх зургийн онцлог зэргээс нь шалтгаалан Монголын үед холбогдуулан үздэг байна.

Бидний Бумбат хайрхан уулын Товорын амнаас илрүүлсэн хоёр морьтон баатрын (Хавсралт 3, Зураг 17, 18) эхний морины толгой хөл, их бие, сүүлийг гоёмсог оор удаах морийг урагшаа тэмүүлж буйгаар маш уран нарийн урласан. Морийг унаж буй хоёр морьтныг нэлээд болхи байдлаар дүрсэлсэн. Өгүүлэн буй хоёр морьтны морины сүүлийг Түрэгийн үед холбогдох морины сүүлтэй тун ижил дүрсэлсэн.

Иймд бид энэхүү хоёр морьтны холбогдох он цагийг Түрэгийн үед холбогдуулан үзэх саналтай байна. Бумбат хайрхан уулын Товорын хадны зураг нь хүрэл зэвсгийн үеэс Түрэгийн үе хүртэлх хугацаанд холбогдох бололтой.

Abstract

NEWLY DISCOVERED PETROGLYPHS FROM THE ALTAI MOUNTAINS

by Tsegmed Munkhbat and Chimeddorj Enkhtur

In 2020, we discovered rock paintings with special images that were not previously included in scientific circulation from Mount Bumbatkhairkhan, located through the territories of Mankhan, Chandman and Zereg soum as a result of a scientific research search. The place where these monuments are located is called “Tovoryn am” on Mount Bumbatkhairkhan. “Tovoryn am” is one of the branching ridges of this mountain. Rock art extends from the mountainside to the top. These drawings date from the Bronze Age to the Middle Ages.

Keywords: Bronze Age, petroglyphs, Bumbatkhairkhan, Zereg, Mankhan, Chandmani, Khovd province

Ном зүй

Батмөнх, Б. (2020). Халхын Засагт хан аймгийн Эрдэнэ засгийн хошууны түүх 1691-1923.

Батсүрэн, Б., Хүүхэнбаатар, Д. (2006). Дэл уулын хадны нэгэн зургийн тухайд. *Studia Historica*. Tom XXXVI. Fasc. 4, УБ., т. 28-29.

Батсүх, Д., Баяр-Арвижих, Х., Төрбат, Ц. (2012). Хүннүгийн эмээлт морины дүрс. *Studia Archaeologica*. Tom. XXXII, Fasc. 12, УБ.,

Баярсайхан, Ж. (2014). Дундад зууны нүүдэлчдийн адууны тоног хэрэгсэл. Талын морьтон дайчдын өв соёл. VII-XIV зууны Монголын хадны оршуулгын шилмэл хэрэглэгдэхүүн каталоги. УБ.,

Волков, В.В. (1980). Оленные камни Монголии. УБ.

Дорж, Д., Новгородова, Э.А. (1975). Петроглифы Монголии. УБ.

Доржсүрэн, Ц. (1961). Умард Хүннү. УБ.

Дүгэрсүрэн, Т. (2010). Жангар. УБ.

Идэрхангай, Т., Цэнд, Д., Амгаланбат, Б., Даваахүү, Э. (2017). Хавцгайтын амны хадны зураг дахь Монгол гүрний үеийн өвөрмөц дүрслэлийн тухайд. // *Studia Archaeologica*. Tom. XXXVI, Fasc. 23, УБ.

Идэрхангай, Т., Цэнд, Д., Амгаланбат, Б., Даваахүү, Э., Батчимэг, Б. (2020). Өмнийн говийн зарим нутгаас

илрүүлсэн хадны зураг дахь морьтон баатруудын дүрслэл. Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Гөлөөн уулын хадны зураг. УБ-ын их сургуулийн эрдэм шинжилгээний бичиг. №16 (15). УБ.

Монгол ардын тууль (1982). Монгол ардын аман зохиолын номын сан. III (5). УБ.

Мөнхбаяр, Ч. (2014). Археологи дахь арван жилийн дурсамж. Ховд,

Потанин, Г.Н. (2017). Монголын баруун хойд нутаг. II боть. 28.

Сүхбаатар, Д., Түвшинжаргал, Т., Баяндэлгэр, Ч. (2017). Дэл уулнаас шинээр илрүүлсэн зураасан зургийн дурсгал. Нүүдэлчдийн өв судлал. Том. XVIII-II. Fasc. 1-27, УБ.

Сүхбаатар, О. (1997). Монгол хэлний харь үгийн толь. УБ.

Цэвэл, Я. (1966). Монгол хэлний товч тайлбар толь. УБ.

Цэвээндорж, Д. (1999). Монголын эртний урлагийн

түүх. УБ.

Цэвээндорж, Д., Батболд, Н. (2008). Шаахар толгойн хадны зураг. УБ.

Цэвээндорж, Д., Кубарев, В.Д., Якобсон, Э. (2010). Шивээт хайрхны хадны зураг. УБ.

Цэвээндорж, Я. Цэрэндагва, Б. Гүнчинсүрэн, Д. Гарамжав (2004). Жавхлант хайрханы хадны зураг. УБ.


Шинэхүү, М. (1972) Дарвийн эртний Түрэг бичээс. Studia Archaeologica. Tom. V. Fasc. 10. УБ.

Энхтөр, Ч., Мөнхбат, Ц. (2016). Бумбат хайрхан уулын хадны зургийн судалгааны эхний үр дүнгээс. Улаанбаатарын их сургуулийн эрдэм шинжилгээний бичиг. Vol. 12 (11). УБ.

Rachewiltz Igor De, (1972). Index to the Secret History of the Mongols. Bloomington. Published by Indiana University.



Зураг- 1.



Зураг- 2.



Зураг- 3.



Зураг- 4.



Зураг- 5.




Зураг-6.



Зураг- 7.



Зураг- 8.




Зураг- 9.



Зүрэг- 10.



Зүрэг- 11.



Зүрэг- 12.



Зүрэг- 13.



Зүрэг- 14.




Зүрэг- 15.



Зүрэг- 16.



Зүрэг- 17.






Зүрэг- 18.



Зүрэг- 19.



Зүрэг- 20.





Зүпар- 28.



Зүпар- 29.



Зүпар- 30.




Зүпар- 31.




Зүпар-32.



Зүпар-33.




Зүр-34.



Зүр-35.

Зүр-36.




Зүр-37.

Зүр-38.




Зүрэг-39.




Зүрэг-40.



Зүрэг-41.



Зүрэг-42.



Зураг-1. Товарын хадны зураг
дахь морьтны дүрслэл



Зураг-2. Товарын хадны зураг
дахь морьтон



Зураг-3. Тэмээ унасан хүний
дүрслэл



Зураг-4. Аргалыг агнаж буй нь



Зураг-5. Олон салаа
эвэртэй буга



Зураг-6. Янгирын дүрслэл




Зураг-7. Сүрэг янгирын дүрслэл



Зураг-8. Морьтны дүрслэл



Зураг-9. Цувж буй янгирын
сүргийн дүрслэл



Морьтонууд зургийн тайлбар

1 - Өмнөговь аймгийн Номгон сумын төвөөс 19 км зайд Аравжихын хадны зураг. (Дорж, Новгородова. Петроглифы Монголии. УБ.,1975. т. 33-35. Рис.76). 2 - Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Цагаан толгойн хийдийн турийн баруун урд талд, голын сайрын зүүн эргийн хадан дээр 38 тооны зохиомжит зургууд бий. Морины гэдэс дор нарийн зураасаар дөрвөлжин гөлөм гэж хэлж болохуйц зүйлийг дүрсэлсэн. (Цэвээндорж Д., Гарамжав Д., Гүнчинсүрэн Б., Цэрэндагва Я., Гантулга Ж., Амартүвшин Ч., Мөнхбат Т. Ханбогдын хадны зураг. УБ.,2010. т. 41-44). 3 - Ардаа хоромсого саадаг гэмээр зүйл ар нуруундаа үүрсэн газар шүргэм урт гөлөмтэй морьтныг дүрсэлсэн. Гөлмийн дундуур морьтой хүний хөлийг унжсан байдалтай урласан. Цагаан толгойн хадны зураг. (Цэвээндорж Д., Гарамжав Д., Гүнчинсүрэн Б., Цэрэндагва Я., Гантулга Ж., Амартүвшин Ч., Мөнхбат Т. Ханбогдын хадны зураг. УБ.,2010. т. 41-44. Рис. 35). 4, 5 - Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Гөлөөн уулын хадны зураг. Өмнийн говийн зарим нутгаас илрүүлсэн хадны зураг дахь морьтон баатруудын дүрслэл. (Идэрхангай Т., Цэнд Д., Амгаланбат Б., Даваахүү Э., Батчимэг Б. Улаанбаатарын их сургууль. Эрдэм шинжилгээний бичиг. №16 (15). УБ.,2020. Зураг-8). 6, 7, 8 - Өмнөговь аймгийн Булган сумын Хавцгайтын хадны зураг. Хавцгайтын хадны зураг дахь Монгол гүрний үеийн өвөрмөц дүрслэлийн тухайд. (Идэрхангай Т., Цэнд Д., Амгаланбат Б., Даваахүү Э. // Археологийн судлал. Том. XXXVI, Fasc. 23, УБ.,2017. Зураг 6-7, 52-р хадны зураг, зураг 8, 54-р хадны зураг). 9, 10 - Өмнөговь аймгийн Сэврэй сумын Хадна уулын хадны зураг. Өмнийн говийн зарим нутгаас илрүүлсэн хадны зураг дахь морьтон баатруудын дүрслэл. (Идэрхангай Т., Цэнд Д., Амгаланбат Б., Даваахүү Э., Батчимэг Б. Улаанбаатарын Их сургууль. Эрдэм шинжилгээний бичиг. №16 (15). УБ.,2020). 11, 12 - БНХАУ-ын Хөх нуурын Цайдмын хотгор Дулааны дурсгалаас олдсон баримал. Дайчин эр баруун гартаа нэгэн зүйлийг барьсан ба морины гэдэс доогуур өргөн гөлөм дүрслээд дайчин эрийн хөлийг унжсан байдалтай дүрсэлжээ. Энэхүү дурсгалын холбогдох он цагийг Умард Вэй, Жинь улсын (НТ 220-589) үед холбогдуулан үздэг. 13 - Франц улсын Гимей музейн сан хөмрөгт хадгалагдаж буй шавар баримал морины дүрс. Энэхүү шавар баримлын холбогдох он цагийг түрүү дундад зууны үеийн Монгол табгач аймгийн нүүдэлчдийн морины тоног хэрэгсэл хэмээн судлаачид үздэг. Дундад зууны нүүдэлчдийн адууны тоног хэрэгсэл. (Баярсайхан Ж. Талын морьтон дайчдын өв соёл. VII-XIV зууны Монголын хадны оршуулгын шилмэл хэрэглэгдэхүүн каталоги. УБ.,2014. т.109-212). 14 - Дундговь аймгийн Өлзийт сумын Дэл уулын Зүүн Билүүний амны дунд биеийн Хөтөл Билүүний хадны дүрслэгдсэн морьтны дүрслэл. (Батсүрэн Б., Хүүхэнбаатар Д. Дэл уулын хадны нэгэн зургийн тухайд. // Studia Historica. Tom. XXXVI, Fasc. 4, УБ.,2006). 15 - Дундговь аймгийн Өлзийт сумын Дэл уулын Баруун Билүүний баруун хойд шувтарга орчмын IV хэсэг хаданд дүрслэгдсэн морьтны дүрслэл. (Сүхбаатар Д., Түвшинжаргал Т., Баяндэлгэр Ч. Дэл уулнаас шинээр илрүүлсэн зураасан зургийн дурсгал. Нүүдэлчдийн өв судлал. Том. XVIII-II, Fasc. 1-27, УБ.,2017. т.131). 16 - Шивээт хайрхан уулын Хар Салаа 1 дурсгалт газарт дүрслэгдсэн урт үстэй хүний дүрслэл (Зураг-10). (Цэвээндорж Д., Кубарев В.Д., Якобсон Э. Шивээт хайрхны хадны зураг. УБ.,2010. т. 93). 17, 18 - Бумбат хайрхан уулын Товорын амны хадны зурагт дүрслэгдсэн морьтны дүрслэлүүд.